



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/186

Арвайхээр сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 5 дугаар баг, Худалдаа-1 гудамж, 117 тоотод байрлах Д.Гялбаа (ЙМ67022816)-н эзэмшлийн худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 704м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр сунгасугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь сунгагдсан иргэнтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0394